

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БУС, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ИРГЭДИЙН ГОМДОЛ, САНАЛ ХҮЛЭЭН АВАХ 1977 УТАСНЫ 11-Р САРЫН ТАЙЛАН

АТГ төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи гомдол, саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг нээлттэй ажиллуулан, ирсэн мэдээллийг судлан үзсэнээр тухайн байгууллагын удирдлагад үйл ажиллагаандаа гаргасан зөрчлөө нэн даруй арилгах арга хэмжээ аван, эргэж мэдээлэхийг үүрэг болгож шаардлага хүргүүлэн ажиллаж байна.


“Глоб Интернэшнл” ТББ нь 1977 утсаар 2007 оны 07 дугаар сарын 09–нөөс эхэлж, энэ оны 12-р сарын 31-нийг дуустал иргэдээс төрийн байгууллагуудын хүнд суртал, төрийн үйлчилгээний ил тод байдал хангалттай бус байгаа талаар гомдол саналыг хүлээн авч, сар бүрийн 05-ын дотор нэгтгэн АТГ болон өөрийн вэб сайтаараа олон нийтэд мэдээлж байна.

2007 оны 11 дугаар сарын 01-ээс 30 хүртэлх хугацаанд 1977 утсаар иргэдээс нийт 41 гомдол, 3 саналыг хүлээн авлаа.

Гомдол өгсөн иргэдийн 97 нь Улаанбаатар хотоос, 3 нь хөдөө орон нутгаас холбогдож мэдээлэл өгсөн.

89 иргэнээс 22 нь өмнө нь тухайн байгууллага албан тушаалтанд хандаж байсан ба эдгээр иргэний дийлэнх нь сүүлийн удаа хандаж байгаатайгаа ижил ба өөр бусад асуудал шийдвэрлүүлэх зорилготой байв. Иргэд зохих журмын дагуу хандаж байсан хэдий ч зөвхөн 1 нь л хүссэн үйлчилгээгээ авч чадсан байна.

Байгууллагын тухай мэдээлэл



Шууд утсанд холбогдсон иргэдийн 32 хувь нь улс; 20 хувь нь аймаг, нийслэлийн; 46 хувь нь сум, дүүргийн; 2 хувь нь баг, хороодын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг төрийн байгууллагуудад хандсан байна.

Байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээр нь харьцуулбал 15 хувь нь эмнэлэгүүдэд, 12 хувь нь газрын албадад, 10 хувь нь засаг даргын тамгын газруудад, 10 хувь нь замын цагдаагийн газруудад, 7 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэх газар албадад, тус тус хандаж гомдол гаргасан байна.



Албан тушаалтны тухай мэдээлэл


Иргэдийн гаргасан гомдлын 32 хувь нь төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан тушаалтнууд, 17 хувь нь төрийн үйлчилгээний байгууллагын мэргэжилтнүүд, 12 хувь нь төрийн тусгай байгууллагын гүйцэтгэх албан тушаалтнууд, 12 хувь нь төрийн захиргааны анхан шатны дарга нарын үйл ажиллагаатай нь тус тус холбоотой байна.



Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл газрын албадын байцаагчид, шүүхийн шийдвэр биелүүлэх газрын байцаагч зэрэг гүйцэтгэх албан тушаалтан, эмнэлгийн эмч, сувилагч зэрэг гүйцэтгэх албан тушаалтнууд иргэдийг чирэгдүүлж байна.

Төрийн байгууллагад иргэдийн хандсан зорилго

Иргэдийн 15 хувь нь эмнэлгүүдэд эмнэлгийн үйлчилгээг авах; 12 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэх газар шүүхийн шийдвэр гаргуулах; 10 хувь нь аюулгүй орчноо хангуулах, 10 хувь нь бичиг баримт бүрдүүлэх, 7 хувь нь өмчлөгчийн нэрийг шилжүүлэх зорилгоор тухайн байгууллагадаа хандсан боловч иргэдийн асуудлыг шийдвэрлэж өгөөгүй.



Байгууллагын цар хүрээгээр авч үзвэл улсын хэмжээний байгууллагад хандсан иргэдийн дийлэнх хувь нь зөвшөөрлийн лиценз авахаар, аймаг нийслэлийн байгууллагуудад хандсан иргэдийн дийлэнх хувь нь өмчлөгчийн нэрийг солиулах, сум дүүргийн хэмжээний байгууллагуудад хандсан иргэдийн дийлэнх хувь нь бичиг баримт авах бүрдүүлэх болон эмнэлгийн үйлчилгээг хүртэх зорилготой тухайн байгууллага, албан тушаалтандаа хандсан боловч асуудлыг шийдвэрлэж өгөөгүй нь дээрх анхан шатны байгууллагуудад иргэдийг чирэгдүүлэх нь их байна гэж үзэх үндэстэй байна.


Гомдол гаргаж байгаа үндэслэл

Гомдол өгсөн иргэдийн 76 хувь нь албан тушаалтнуудыг хүнд сурталтай, иргэдийг чирэгдүүлж байна, 42 хувь нь үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу шийдвэрлэвэл зохих асуудлаа шийдвэрлэж өгөхгүй байна; 23 хувь нь байгууллагын дүрэм журам ба хууль заасан хугацаандаа шийдвэрлэж өгөхгүй байна, 15 хувь нь ажилтан, албан тушаалтнууд ажлаа мэддэггүй, 12 хувь нь иргэдээс үндэслэлгүйгээр нэмэлт төблөр хураамж шаардаж байна зэрэг шалтгаануудыг дурьдаж байв.



Байгууллагын цар хүрээгээр нь авч үзвэл улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудад албан тушаалтнууд нь хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлэх, үйл ажиллагааны чиглэлийнхээ чиглэлийнхээ дагуу шийдвэрлэвэл зохих асуудлаа шийдвэрлэж өгөхгүй байх; аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудад албан тушаалтнууд нь хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлэх; сум, дүүргийн хэмжээний байгууллагуудад албан тушаалтнууд нь хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлэх, үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу шийдвэрлэвэл зохих асуудлаа шийдвэрлэж өгөхгүй байх, албан тушаалтнууд нь улсын болон бусдын эд хөрөнгийг завших; харин баг хорооны байгууллагуудын албан хаагчид ажлаа мэддэггүй, хариуцлагагүй хандах зэрэг зөрчлүүд ихээр гаргаж байгаа нь ажиглагдлаа.


Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл газрын албадад албан тушаалтнууд нь албан тушаалаа урвуулан ашиглаж улсын болон бусдын эд хөрөнгийг завших; эмнэлгүүдийн хувьд байгууллагын дүрэм болон хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэж өгөхгүй байх; замын цагдаагийн газар, тасгуудад байгууллагын дүрэм болон хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэж өгөхгүй, ба хууль дүрмэнд заасан хугацаанд асуудлыг шийдвэрлэж өгөхгүй; шүүхийн шийдвэр биелүүлэх газар, албадад байгууллагын дүрэм болон хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэж өгөхгүй; харин засаг даргын тамгын газруудын хувьд бол хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй, албан тушаалаа урвуулан ашиглаж бусдын болон улсын эд хөрөнгийг завших болон үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр авч байна.



Төрийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд зарцуулсан хугацаа

Энэ сард шууд утсаар холбогдсон иргэдийн 68 хувь нь буюу гомдол гаргасан байгууллагадаа хандаад нэг сар болоогүй, 13 хувь нь 1-ээс 3 сар, 10 хувь нь 7 сараас нэг жил, 7 хувь нь 2-оос дээш жил, 3 хувь нь 4-өөс 6 сар болж байна.

Асуудлаа шийдвэрлүүлж чадалгүй нэг сар болж байгаа иргэд энэ сард их холбогдсон нь төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтнууд хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлэх; үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу асуудлыг шийдвэрлүүлж өгөхгүй байх зөрчлүүд нийт гомдлын талаас илүү хувийг эзэлж байгаатай холбоотой.



Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд зарцуулсан хугацааг байгууллагуудын цар хэмжээгээр нь харьцуулж үзвэл нийслэлийн байгууллагуудад хандаад нэг сар болоогүй иргэд 13 хувь нь байхад улс, аймгийн хэмжээний байгууллагуудад хандаад нэг сар болоогүй иргэд 26 хувьтай байна.

Иргэдийн саналын тухай мэдээлэл

Шууд утсанд нийт 3 иргэн хандаж санал гаргасан ба тэд Улаанбаатар хотоос холбогджээ. Иргэдийн саналыг дор дурьдлаа. Үүнд:

Санал 1. АТГ-ын холбогдох албан тушаалтнуудын “Сонгино Хангай” ХХК нь өнгөрсөн хугацаанд 2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Харин үүнээс СХД-ийн татварын хэлтэст зөвхөн 300 сая төгрөгийн татвар төлжээ. Энэ нь тус байгууллагын үйл ажиллагаатай шууд холбоотой гэж үзэж байна. Та бүхэн СХД-ийн Татварын хэлтсийг шалгаж өгнө үү”/Үүнийг нотлох баримт бий/

Санал 2. СХД-ийн замын цагдаагийн тасгийн техник, тоо бүртгэлийн ажилтнуудад “Тус замын цагдаагийн тасаг нь иргэдийг зөвхөн 09.30-аас 12.30 цагийн хооронд хүлээн аваад бусад үед баримт материал дээрээ ажилладаг нь иргэдийг хүлээлгэж, чирэгдүүлж байна. Иймээс иргэдийг хүлээж авах цагийг нь уртасгах хэрэгтэй. Ажлын цаг амьдралаас тасархай, ийм уялдаа холбоогүй байж болохгүй.”

Санал 3. “Хэвлэл мэдээллийн байгууллагаар, ялангуяа радио, телевизээр санал бодлоо хэлэх, хэвлэн нийтлэх гэхээр авлига авсан хүнийхийг хүлээж авдаг юм байна. Эсвэл олны танил нэртэй хүмүүсийн материалыг хэвлэх, ярилцлага өгүүлдэг. Харин жирийн иргэдээс заавал гар хардаг. Энэ байдлыг нь болиулах арга хэмжээ авч өгөөч. Үүнийг яаж таслан зогсоох вэ”

ХАВСРАЛТ – 1

1. Байгууллагын тухай мэдээлэл

- Харьяалал

	Иргэдийн гомдлын тоо	Иргэдийн гомдол эзлэх хувь
Улсын	12	29.3
Нийслэл	8	19.5
Баянгол дүүрэг	3	7.3
Баянгзүрх дүүрэг	5	12.2
Сонгинохайрхан дүүрэг	6	14.6
Хан Уул дүүрэг	2	4.9
Чингэлтэй дүүрэг	1	2.4
Баян Өлгий аймаг	1	2.4
Булган аймаг	1	2.4
Орхон аймаг	1	2.4
Хэнтий	1	2.4
Нийт	41	100.0

- Үйл ажиллагааны цар хүрээ

	Иргэдийн гомдлын тоо	Иргэдийн гомдол эзлэх хувь
Улс	13	31.7
Нийслэл, аймаг	8	19.5
Дүүрэг, сум	19	46.3
Хороо, баг	1	2.4
Нийт	41	100.0

- Үйл ажиллагааны чиглэл

	Иргэдийн гомдлын тоо	Иргэдийн гомдол эзлэх хувь
Яамд	1	2.4
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	3	7.3
Засаг даргын тамгын газар	4	9.8
Үндэсний татварын ерөнхий газар	1	2.4
Цагдаагийн ерөнхий газар	2	4.9
Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	1	2.4
Замын цагдаагийн газар	4	9.8
Эрүүл мэндийн газар	6	14.6
Газрын албад	5	12.2
Шүүх	1	2.4
Боловсролын газар	1	2.4
Иргэний бүртгэл мэдээллийн төв	1	2.4
Эд хөрөнгө эрхийн бүртгэлийн газар	1	2.4
Мэргэжлийн хяналтын газар, алба	3	7.3
Онцгой байдлын газар	1	2.4
Хот тохижилт үйлчилгээний алба	2	4.9
Төмөр зам	2	4.9
Нийтийн тээврийн газар	1	2.4

2. Албан тушаалтны мэдээлэл

- Албан хаагчдын албан тушаалын зэрэглэл

	Иргэдийн гомдол /тоогоор/	Ирэгдийн гомдол /эзлэх хувь/
Улс төрийн удирдах албан тушаал	1	2.4
Улс төрийн анхан шатны удирдах албан тушаал	2	4.9
Төрийн захиргааны удирдах албан тушаал	3	7.3
Төрийн захиргааны удирдан гүйцэтгэх албан тушаал	5	12.2
Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	13	31.7
Төрийн тусгай гүйцэтгэх албан тушаал	5	12.2
Төрийн үйлчилгээний удирдах албан тушаал	1	2.4
Төрийн үйлчилгээний удирдан гүйцэтгэх албан тушаал	1	2.4
Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаал	7	17.1
Төрийн дөрвөн байгууллагын бага тушаалын албан тушаал	3	7.3
Нийт	41	100.0

- Албан тушаалтны нэрийг хэлсэн эсэх

	Иргэдийн гомдол /тоо/	Иргэдийн гомдол /эзлэх хувь/
Тийм	33	80.5
Үгүй	8	19.5
Total	41	100.0

- Байгууллагын цар хүрээгээр

	Улс	Нийслэл, аймаг	Дүүрэг, сум	Хороо, баг	Нийт
Улс төрийн удирдах албан тушаал	-	12.5	-	-	2.4
Улс төрийн анхан шатны удирдах албан тушаал	-	-	10.5	-	4.9
Төрийн захиргааны удирдах албан тушаал	23.1	-	-	-	7.3
Төрийн захиргааны удирдан гүйцэтгэх албан тушаал	7.7	12.5	15.8	-	12.2
Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	38.5	62.5	15.8	-	31.7
Төрийн тусгай гүйцэтгэх албан тушаал	7.7	-	21.1	-	12.2
Төрийн үйлчилгээний удирдах албан тушаал	7.7	-	-	-	2.4
Төрийн үйлчилгээний удирдан гүйцэтгэх албан тушаал	-	-	5.3	-	2.4
Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаал	-	12.5	26.3	100.0	17.1
Төрийн дөрвөн байгууллагын бага тушаалын албан тушаал	15.4	-	5.3	-	7.3
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0

- Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр

	Улс төрийн удирдах албан тушаал	Улс төрийн анхан шатны удирдах албан тушаал	Төрийн захиргааны удирдах албан тушаал	Төрийн захиргааны удирдан гүйцэтгэх албан тушаал	Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	Төрийн тусгай гүйцэтгэх албан тушаал	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаал	Төрийн үйлчилгээний удирдан гүйцэтгэх албан тушаал	Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаал	Төрийн дөрвөн байгууллагын бага тушаалын албан тушаал
Яамд	-	-	-	-	7.7	-	-	-	-	-
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	-	-	33.3	-	15.4	-	-	-	-	-
Засаг даргын тамгын газар	-	100.0	-	-	15.4	-	-	-	-	-
Үндэсний татварын ерөнхий газар	-	-	-	20.0	-	-	-	-	-	-
Цагдаагийн ерөнхий газар	-	-	-	-	-	20.0	-	-	-	33.3
Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	-	-	-	-	-	-	-	-	14.3	-
Замын цагдаагийн газар	-	-	-	-	-	80.0	-	-	-	-
Эрүүл мэндийн газар	-	-	-	-	-	-	-	-	71.4	33.3
Газрын албад	100.0	-	-	20.0	23.1	-	-	-	-	-
Шүүх	-	-	-	20.0	-	-	-	-	-	-
Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	100.0	-	-
Иргэний бүртгэл мэдээлэл	-	-	-	-	7.7	-	-	-	-	-
Эд хөрөнгө эрхийн бүртгэл	-	-	-	-	7.7	-	-	-	-	-
Мэргэжлийн хяналт	-	-	66.7	20.0	-	-	-	-	-	-
Онцгой байдал	-	-	-	20.0	-	-	-	-	-	-
Хот тохижилт үйлчилгээ	-	-	-	-	15.4	-	-	-	-	-
Төмөр зам	-	-	-	-	7.7	-	100.0	-	-	-
Нийтийн тээвэр	-	-	-	-	-	-	-	-	14.3	-
Нийт	-	-	-	-	-	-	-	-	-	33.3

3. Төрийн байгууллагад хандсан асуудал

- Хандсан асуудал

	Иргэдийн гомдлын тоо	Иргэдийн гомдол эзлэх хувь
Нөхөн төлбөр, тэтгэвэр тэтгэмж авах	1	2.4
Өмч эзэмших эрхийн бичиг авах	2	4.9
Өмчөө буцааж авах	2	4.9
Аюулгүй амьдрах орчноо хангуулах	4	9.8
Шүүхийн шийдвэрийн дагуу хохирлоо барагдуулах	5	12.2
Эмнэлгийн үйлчилгээ авах	6	14.6
Өмчлөгчийн нэрийг шилжүүлэх	3	7.3
Тодорхойлолт авах	1	2.4
Бусад	5	12.2
Тухайн байгууллагад хандаагүй	4	9.8
Гадаадад зорчих	1	2.4
Бичиг баримт авах, бүрдүүлэх	4	9.8
Зөвшөөрөл, лиценз авах	3	7.3
Нийт	41	100.0

- Байгууллагуудыг үйл ажиллагааных нь цар хүрээгээр

	Улс	Нийслэл, аймаг	Дүүрэг, сум	Хороо, баг	Нийт
Шүүх, цагдаагийн байгууллагын шийдвэрт нөлөөлсөн	-	-	-	100.0	2.4
Хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй байна	23.1	-	21.1	-	17.1
Өөрөө гэмт хэрэгтнүүдтэй хуйвалдаж байна	7.7	-	-	-	2.4
Их хэмжээний мөнгө завшиж байна	7.7	-	5.3	-	4.9
Үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр нэхэж байна	-	-	15.8	-	7.3
Албан тушаалаа ашиглаж улсын болон бусдаын эд хөрөнгийг завшиж	-	25.0	10.5	-	9.8
Хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байна	23.1	50.0	10.5	-	22.0
Олон шат дамжлагатай байна	-	-	5.3	-	2.4
Хүнд суртал, чирэгдэлтэй байна	30.8	12.5	21.1	-	22.0
Ажлаа мэддэггүй, хариуцлагагүй хандсан	7.7	12.5	10.5	-	9.8
Өөрөө гэмт хэрэгтнүүдтэй хуйвалдаж байна	100.0	100.0	100.0	100.0	100.0

4. Тухайн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд зарцуулсан хугацаа

- Тухайн байгууллагад хандаад зарцуулсан хугацаа /бүлгээр/

	Иргэдийн гомдол /тоо/	Иргэдийн гомдол /эзлэх хувь/
Нэг сар болоогүй	21	67.7
1-3 сар	4	12.9
4-6 сар	1	3.2
7 сараас нэг жил	3	9.7
2-оос дээш жил	2	6.5

- Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээгээр

	Нэг сар болоогүй	1-3 сар	4-6 сар	7-12 сар	1-2 жил	2-оос дээш жил
Улс	38.1	25.0	100.0	-	-	32.3
Нийслэл, аймаг	19.0	25.0	-	66.7	50.0	25.8
Дүүрэг, сум	38.1	50.0	-	33.3	50.0	38.7
Хороо, баг	4.8	-	-	-	-	3.2
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

- Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр

	Нэг сар болоогүй	1-3 сар	4-6 сар	7-12 сар	1-2 жил	2-оос дээш жил
Яамд	-	25.0	-	-	-	3.2
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	4.8	50.0	-	-	-	9.7
Засаг даргын тамгын газар	14.3	-	-	33.3	-	12.9
Цагдаагийн ерөнхий газар	9.5	-	-	-	-	6.5
Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	-	-	-	33.3	-	3.2
Замын цагдаагийн газар	9.5	-	100.0	-	-	9.7
Эрүүл мэндийн газар	14.3	-	-	-	-	9.7
Газрын албад	4.8	25.0	-	33.3	100.0	16.1
Шүүх	4.8	-	-	-	-	3.2
Иргэний бүртгэл мэдээллийн төв	4.8	-	-	-	-	3.2
Эд хөрөнгө эрхийн бүртгэлийн төв	4.8	-	-	-	-	3.2
Мэргэжлийн хяналтын	4.8	-	-	-	-	3.2
Хот тохижилт үйлчилгээ	9.5	-	-	-	-	6.5
Төмөр зам	4.8	-	-	-	-	3.2
Нийтийн тээврийн газар	4.8	-	-	-	-	3.2
36.0	4.8	-	-	-	-	3.2
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

- Байгууллагын албан тушаалтны зэрэглэлээр

	Нэг сар болоогүй	1-3 сар	4-6 сар	7-12 сар	1-2 жил	2-оос дээш жил
Улс төрийн удирдах албан тушаал	-	-	-	-	50.0	3.2
Улс төрийн анхан шатны удирдах албан тушаал	9.5	-	-	-	-	6.5
Төрийн захиргааны удирдах албан тушаал	9.5	-	-	-	-	6.5
Төрийн захиргааны удирдан гүйцэтгэх албан тушаал	4.8	-	-	33.3	-	6.5
Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	33.3	100.0	-	33.3	50.0	41.9
Төрийн тусгай гүйцэтгэх албан тушаал	14.3	-	100.0	-	-	12.9
Төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаал	14.3	-	-	33.3	-	12.9
Төрийн дөрвөн байгууллагын бага тушаалын албан тушаал	14.3	-	-	-	-	9.7
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

- Байгууллагад хандсан иргэдийн зорилго

	Нэг сар болоогүй	1-3 сар	4-6 сар	7-12 сар	1-2 жил	2-оос дээш жил
Нөхөн төлбөр, тэтгэвэр тэтгэмж авах	-	-	-	33.3	-	3.2
Өмч эзэмших эрхийн бичиг авах	-	-	-	-	100.0	6.5
Өмчөө буцааж авах	-	25.0	-	33.3	-	6.5
Аюулгүй амьдрах орчноо хангуулах	14.3	-	-	-	-	9.7
Шүүхийн шийдвэрийн дагуу хохирлоо барагдуулах	14.3	25.0	100.0	-	-	16.1
Эмнэлгийн үйлчилгээ авах	14.3	-	-	-	-	9.7
Өмчлөгчийн нэрийг шилжүүлэх	4.8	25.0	-	33.3	-	9.7
Тодорхойлолт авах	4.8	-	-	-	-	3.2
Бусад	4.8	-	-	-	-	3.2
Тухайн байгууллагад хандаагүй	14.3	-	-	-	-	9.7
Гадаадад зорчих	4.8	-	-	-	-	3.2
Бичиг баримт авах, бүрдүүлэх	14.3	-	-	-	-	9.7
Зөвшөөрөл, лиценз авах	9.5	25.0	-	-	-	9.7
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

5. Иргэдийн мэдүүлсэн гомдлын үндэслэл

- Гомдлын үндэслэл

	Иргэдийн гомдлын тоо	Иргэдийн гомдол эзлэх хувь
Шүүх, цагдаагийн байгууллагын шийдвэрт нөлөөлсөн	1	2.4
Хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй байна	11	26.8
Өөрөө гэмт хэрэгтнүүдтэй хуйвалдаж байна	1	2.4
Их хэмжээний мөнгө завшиж байна	3	7.3
Үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр нэхэж байна	5	12.2
Албан тушаалаа ашиглаж улсын болон бусдаын эд хөрөнгийг завшиж	13	31.7
Хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байна	17	41.5
Олон шат дамжлагатай байна	2	4.9
Хүнд суртал, чирэгдэлтэй байна	31	75.6
Ажлаа мэддэггүй, хариуцлагагүй хандсан	6	14.6

- Төрийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээгээр авч үзвэл

	Улс	Нийслэл, аймаг	Дүүрэг, сум	Хороо, баг
Шүүх, цагдаагийн байгууллагын шийдвэрт нөлөөлсөн	-	-	-	100.0
Хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй байна	30.8	12.5	31.6	-
Өөрөө гэмт хэрэгтнүүдтэй хуйвалдаж байна	7.7	-	-	-
Их хэмжээний мөнгө завшиж байна	7.7	-	10.5	-
Үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр нэхэж байна	-	-	26.3	-
Албан тушаалаа ашиглаж улсын болон бусдаын эд хөрөнгийг завшиж	7.7	62.5	36.8	-
Хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байна	38.5	62.5	36.8	-
Олон шат дамжлагатай байна	7.7	-	5.3	-
Хүнд суртал, чирэгдэлтэй байна	84.6	75.0	73.7	-
Ажлаа мэддэггүй, хариуцлагагүй хандсан	15.4	12.5	10.5	100

ХАВСРАЛТ – 2

Зөрчил гаргасан ажилтан, албан тушаалтнуудын нэрс:

289. Солонгосын элчин сайдын яамны виз хариуцсан монгол ажилтнууд
290. СХД-ын цагдаагийн хэлтсийн байцаагч, хошууч Энх-Амгалан
291. Иргэний Бүртгэл Мэдээллийн төвийн бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Наранцэцэг
292. Нийслэлийн тээвэр үйлчилгээний төвийн аж ахуйн гэрээний мэргэжилтэн Зоригтбаатар
293. ХУД-ын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албаны ажилтнууд
294. “Оюун Ундраа” цогцолборын 4.1-ийн, анги удирдсан багш Цэнд-Аюуш, захирал Нэргүйдаваа
295. Булган аймгийн Дашинчилэн сумын эмнэлийн их эмч Соёлмаа
296. БЗД-ийн замын цагдаагийн тасгийн байцаагч Даваатөгс
297. Улсын мэргэжлийн хяналтын газрын мэргэжлийн хяналт шалгалтын албаны дарга Гантөмөр
298. Замын цагдаагийн ерөнхий газрын дэд хурандаа Оюунчимэг, хошууч Ганболд
299. СХД-ийн цагдаагийн хэлтсийн 133, 102 дуудлагын утасны мэдэлэл хүлээн авагчид
300. Эрүүл мэндийн хяналтын улсын албаны хэлтсийн дарга Тогтохбаяр, дарга Оюунчимэг
301. Байгаль Орчны Яамны байгаль орчны үнэлгээ хийдэг ажилтнууд
302. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төрөхийн их эмч Мавлет
303. БЗД-ын газрын албаны байцаагч, Ганбат, Мөнхбаатар
304. БЗД, IV хорооны засаг дарга Ганхүрэл, зохион байгуулагч Сэржбүдээ
305. Хэнтий аймгийн Тайшир сумын Засаг дарга Энхтайван
306. Нийслэлийн газрын албаны СХД хариуцсан төлбөрийн хэлтсийн дарга Дашцэцэг
307. Нийслэлийн захирагчийн албаны менежер Амгаланбаяр, орон сууц хариуцсан мэргэжилтэн Уянга
308. СХД-ийн шүүхийн нарийн бичгийн дарга Түмэнцэцэг
309. Вокзалын 1-р давхарын 1-р номерын ээлжийн ахлагч
310. Нийслэлийн кадастерын албаны мэргэжилтэн С.Баярхүү
311. Барилга хот байгуулалт төлөвлөлтийн газарын инженер Оргил, Цэрмаа
312. БЗД-ийн замын цагдаагийн тасгийн ахмад Цогтсайхан, ахлагч Ганбаатар
313. СХД-ийн шүүхийн шийдвэр биелүүлэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч Батболд
314. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Батжаргал
315. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нарийн бичгийн дарга Туяа
316. БГД-ийн татварын хэлтсийн дарга Оюунтуяа
317. Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Энхтайван
318. Сонгино-Хайрхан дүүргийн “Алтан цэгцүүхэй” өрхийн эмнэлгийн 1-р байрыг хариуцсан эмч
319. БГД-ийн эрхийн эмнэлэг “Угтахуй” өрхийн эмч нар
320. Эрдэнэт хотын төмөр замын дарга Олзбаатар
321. УК-1-р эмнэлгийн тарианы сувилагч
322. Хоты дарга Батбаяр, Нийслэлийн газрын албаны орлогч дарга
323. Улсын бүртгэлийн албан байцаагч Баяржаргал
324. ЧД-ийн газрын албаны байцаагч Алтанхуяг, Алтанцэцэг
325. БЗД-ийн замын цагдаагийн тасгийн ахмад Цогтсайхан, дэд ахлагч Ганбаатар
326. ХУД-ийн 4-р хорооны эрхийн эмнэлгийн эмч Оюун
327. Нийслэлийн газрын албаны БГД хариуцсан байцаагч Сүхчулуун
328. СХД-ийн онцгой байдлын албаны дарга Дугаржав, байцаагч Мөнхбат
329. УБ хотын захирагчийн албаын орон сууц хариуцсан мэргэжилтэн Э.Уянга